

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Туулын хишиг ОНӨААТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/06-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ч.Цэрэннадмид Утас: 95112689 Цахим хаяг: ts.nadiii@yahoo.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
3.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	12
4.Аудитын тайлан.....	12
4.1. Ерөнхий зүйл.....	12
4.2 Дотоод хяналт.....	13
4.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
4.4. Материаллаг байдал	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	13
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Албан шаардлага	15
8.3 Зөвлөмж	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УИХ	Улсын их хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**“ТУУЛЫН ХИШИГ” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Л.ГАНТУЛГА ТАНАА**

2022.03.15 № СЭА-2022/06-НА-ОН-ОНА
тантай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Үйлдвэрийн газрын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй,
- Шууд худалдан авах босго үнээс давсан 80,160.4 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн,
- Газар тариалангийн 364 га талбайг иргэн Д.Амарсанаад 141,074.0 мянган төгрөгөөр түрээслүүлсний 20 хувь болох 28,214.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй,

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3 дахь “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Төндөр шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, “Босго үнэ СЭА-2022/06-НА-СТА-ОНА

шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтын 2 дахь “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 20,0 сая төгрөг”, Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2014 оны 25 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн өмч, эд хөрөнгийг түрээслүүлэх журмын 2.14 дэх “Түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 20 хувийг орон нутгийн төсвийн орлогын дансанд байршуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,084,923.01	27,141,526.33
1.1.4	Дансны авлага	84,495,962.61	76,834,376.92
1.1.5	Найдваргүй авлагын хасагдуулга	1,166,680.00	1,166,680.00
1.1.7	Бараа материал	11,167,446.00	10,972,878.29
1.1.9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		400,000.00
1.1.10	Ажилчдаас авах авлага	270,000.00	199,000.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	100,185,011.62	116,714,461.54
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	377,812,989.30	354,330,435.24
1.2.7	Биет бус хөрөнгө	1,484,696,000.00	1,484,696,000.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,862,508,989.30	1,839,026,435.24
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,962,694,000.92	1,955,740,896.78
2	Эргэлтийн бус хөрөнгө		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	142,735,034.13	8,595,838.03
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Орлогын татварын өглөг		11,819,062.80
2.1.1.4	ХАОАТ-ын өглөг	2,848,931.22	3,823,537.83
2.1.1.5	НӨАТ-ын өглөг	38,660,634.50	23,606,528.51
2.1.1.6	Бусад татварын өглөг		345,000.00
2.1.1.7	ЭМНД -ийн шимтгэлийн өглөг	11,196,641.99	
2.1.1.10	Бусад өглөг	2,353,370.00	36,770,959.57
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	197,794,611.84	84,960,926.74
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5	Урт хугацаат өглөгийн хасагдуулга		1,166,680.00
2.1.2.6			
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	1,166,680.00
2.1.2.20	Өр төлбөрийн нийт дүн	197,794,611.84	86,127,606.74
2.2	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.2.1	Өмч : а) төрийн	1,958,488,000.00	1,958,488,000.00
2.2.4	Хувьцаат капиталын дүн	1,958,488,000.00	1,958,488,000.00
2.2.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.2.6	Дахин үнэлгээний нөөц	164,604,304.98	164,604,304.98
2.2.7	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		
2.2.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(358,192,915.90)	(253,479,014.94)
2.2.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,764,899,389.08	1,869,613,290.04
2.3.20	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	1,962,694,000.92	1,955,740,896.78

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант улирлын дүн
1	Борлуулалтын орлого /цэвэр/	222,751,426.34	387,250,886.80
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	231,894,277.53	229,573,895.03
3	Нийт ашиг (алдагдал)	(9,142,851.19)	157,676,991.77
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	37,288,305.76	39,486,363.26
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/		
17	Бусад ашиг /алдагдал/		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(46,431,156.95)	118,190,628.51
19	Орлогын татварын зардал		11,819,062.80
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(46,431,156.95)	106,371,565.71
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(46,431,156.95)	106,371,565.71
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз /гарз/		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)		-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх үеийн	Тайлант үеийн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	247,132,060.71	417,681,628.80
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	245,678,622.01	254,181,628.80
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Бусад мөнгөн орлого	1,453,438.70	163,500,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	244,160,544.91	393,625,025.48
	Ажилчдад төлсөн	57,869,276.00	62,756,675.65
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,677,985.00	36,007,108.97
	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	55,156,288.35	202,154,177.34
	бичиг хэргийн зардал		
	Ашиглалтын зардалд төлсөн	2,280,160.00	36,213,172.69
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,364,923.00	6,338,852.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	114,932,322.56	41,965,399.83
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	879,590.00	8,189,639.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,971,515.80	24,056,603.32
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн		-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн		-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн		-
	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,971,515.80	24,056,603.32
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	113,407.21	3,084,923.01

5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,084,923.01	27,141,526.33
------------	--	---------------------	----------------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг алдагдал	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,958,488,000.00		164,604,304.98	(358,192,915.90)	1,764,899,389.08
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
3	Залруулсан үлдэгдэл	1,958,488,000.00	-	164,604,304.98	(358,192,915.90)	1,764,899,389.08
4	Өмчийн өөрчлөлт					-
8	Тайлант үеийн цэвэр ашиг					-
9	Ногдол ашиг					-
10	Гаргасан хувьцаат капитал					-
11	2020 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	1,958,488,000.00	-	164,604,304.98	(358,192,915.90)	1,764,899,389.08
12	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
13	Залруулсан үлдэгдэл	1,958,488,000.00	-	164,604,304.98	(358,192,915.90)	1,764,899,389.08
14	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				(1,657,664.75)	(1,657,664.75)
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц					-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
17	Тайлант үеийн цэвэр ашиг				106,371,565.71	106,371,565.71
18	Ногдол ашиг					-
19	Гаргасан хувьцаат капитал					-
20	2021оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,958,488,000.00	-	164,604,304.98	(253,479,014.94)	1,869,613,290.04

Хүснэгт 1. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	м/төг	222,751.4	281,507.0	387,250.9	105,743.9	137.5
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	222,751.4	281,507.0	387,250.9		
3	Нийт зардал	м/төг	269,182.6	279,842.2	269,060.3	(10781.9)	96.1
	Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг	231,894.3		229,573.9		
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	37,288.3		39,486.4		
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг					
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төг	(46,431.2)	1,664.8	118,190.6		

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Туулын хишиг ОНӨААТҮГ нь *“Орчин үеийн техник технологи нэвтрүүлэн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл үйлчилгээ явуулж хэрэглэгчдийг дулааны эрчим хүч, хэрэглээний цэвэр усаар найдвартай хангаж, эдийн засгийн алдагдлыг бууруулах замаар салбартаа тэргүүлэгч байгууллага болно”* гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Туулын хишиг ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төв дэх төсвийн байгууллагуудын дулаан хангамж, тохижилт, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарим засвар үйлчилгээг харилцан гүйцэтгэх, хяналт тавих.
- Сумын төв, хөдөөд газар тариалан эрхлэх, дулаан цэвэр усаар хангах иргэн, байгууллагатай гэрээ хийх, ашиглалтын төлбөр тооцоо хийх.
- Орон нутгийн өмчийн техник бусад хэрэгслээр төсвийн байгууллагад захиалгат үйлчилгээг тогтоосон үнэ тарифаар үзүүлэх гэх мэт.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Туулын хишиг ОНӨААТҮГ-ыг сумын ИТХ-ын 2009 оны 51 дүгээр тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд *“Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”*, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д *“Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д *“Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”* гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор “Айл өрхийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн

хог хаягдлын үйлчилгээний хураамж"-ийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Туулын хишиг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,084.9	27,141.5	24,056.6
Авлага	84,495.9	76,834.4	(7,661.5)
Найдваргүй авлагын хасагдуулга	1,166.7	1,166.7	-
Ажилчдаас авах авлага	270.0	199.0	(71.0)
Урьдчилж төлсөн зардал	-	400.0	400.0
Бараа материал	11,167.4	10,972.9	(194.5)
Үндсэн хөрөнгө	377,813.0	354,330.4	(23,482.6)
Биет бус хөрөнгө	1,484,696.0	1,484,696.0	-
Нийт хөрөнгө	1,962,694.0	1,955,740.9	(6,953.1)
Өр төлбөр	197,794.6	86,127.6	(111,667.0)
Эздийн өмч	1,958,488.0	1,958,488.0	
Эздийн өмчийн бусад хэсэг	164,604.3	164,604.3	
Хуримтлагдсан ашиг	(358,192.9)	(253,479.0)	(104,713.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	741,951.2	704,136.2	(6,953.1)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 24,056.6 мянган төгрөгөөр өссөн нь 417,681.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 393,625.0 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 7,661.5 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн нэгж байгууллагаас авах авлагын оны эхний үлдэгдлийг барагдуулснаас голлон шалтгаалсан байна. Тайлант оны нийт авлагын үлдэгдлийн 1,120.2 мянган төгрөг нь айл өрхөөс авах дулааны төлбөр, 8,700.0 мянган төгрөг нь газрын түрээсийн, **27,268.1** мянган төгрөг нь эзэн холбогдогч тодорхой бус дансны авлага, 39,746.1 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудаас авах дулааны авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 194.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 78,043.3 мянган төгрөгийн нүүрс, 11,878.7 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авч, 90,116.5 мянган төгрөгийн материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэлд */анхны өртгөөр/* ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 111,667.0 мянган төгрөгөөр буурсан нь дансны өглөг, НӨАТ-ын өглөг буурсантай холбоотой байна. Нийт өглөгийн үлдэгдэл 86,127.6 мянган төгрөгийн 46 хувь буюу 39,594.1 мянган төгрөг нь татварын өглөг, 42.1 хувь буюу 36,288.6 мянган төгрөг нь “Жаргалант Алтай” ХХК-д төлөх нүүрсний өглөг, 11.9 хувь буюу 10,244.9 мянган төгрөг нь бусад дансны өглөг байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 253,479.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 104,713.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Туулын хишиг ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, сумын ИТХ-аар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Туулын хишиг ОНӨААТҮГ нь 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулалгүйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд гүйцэтгэлээр 387,250.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 269,060.3 мянган төгрөгийн зардал гарган, 118,190.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Туулын хишиг ОНӨААТҮГ-ын */цаашид Туулын хишиг ОНӨААТҮГ-ын гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, аудитор Ш.Ганчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Туулын хишиг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

“Туулын Хишиг” ОНӨААТҮГ нь аймгийн ТЕЗ-ийн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

4.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Туулын хишиг ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

4.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 269,060.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,690.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,884.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Туулын хишиг ОНӨААТҮГ нь тайлант онд 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 10 мэдээллийг огт мэдээлээгүй бол 24 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь Холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь шилэн дансны цахим санд мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;” гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 190.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 83,115.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 4,281.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөнөөс төлбөрийн актыг барагдуулж, 2 албан шаардлага, 3 зөвлөмжийг биелүүлсэн байна.

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	190.0	1	190.0	100.0
Албан шаардлага	3	83,115.1	2	2,407.4	66.7
Зөвлөмж	4	4,281.2	3	4,281.2	75.0
Нийт дүн	8	87,586.3	6	6,878.6	75.0

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Шууд худалдан авах босго үнээс давсан нүүрсний худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлээгүй, тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх *“Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй.....нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”* гэсэн заалтын дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг “0” үлдэгдэлтэй болсон 224,340.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 16 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа тул НББОУС-ын Үндсэн хөрөнгө 16-ын 34-д *“... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс ихээхэн ялгаатай бол дахин үнэлээг зайлшгүй хийнэ”* гэж заасны дагуу хөрөнгийг цаашид ашиглахаар бол дахин үнэлэх эсвэл акталж устгах тухай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 105,579.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 14,362.4 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 91,217.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй, материаллаг 91,217.3 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 2,691.8 мянган төгрөгийн түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 14,362.4 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд орлогын албан татвар 11,819.1 мянган төгрөгийг ноогдуулаагүй.
- Татварын торгуульд төлсөн 2,543.3 мянган төгрөгийг удирдлагын зардалд бүртгэж татвар ногдох зардлаас хасагдсаныг залруулсан.

8.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс шууд худалдан авах босго үнээс давсан 63,002.5 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг Алтан Очир суврага ХХК, Монкоул петро майнинг ХХК, Хур ширээ ХХК, Цэцэнс Майнинг ХХК, Техно Преспектив ХХК-иудаас шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх *“Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”*, *“Босго үнэ шинэчлэн батлах тухай”* Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтын 2 дахь *“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 20,0 сая төгрөг”* гэсэн заалтыг тус тус

зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

2. Газар тариалангийн 364 га талбайг иргэн Д.Амарсанаад 141,074.0 мянган төгрөгөөр түрээслүүлсний 20 хувь болох 28,214.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2014 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн өмч, эд хөрөнгийг түрээслүүлэх журмын 2.14 дэх “Түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 20 хувийг орон нутгийн төсвийн орлогын дансанд байршуулна” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн орлогын 20 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Үйлдвэрийн газрын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, **зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах**” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулж, мөрдөх албан шаардлага хүргүүлэх.

8.3 Зөвлөмж

1.Татварын зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Газар тариалангийн талбайн түрээсийн орлогыг НӨАТ-ын тайланд дутуу тайлагнасан нь татварын хяналт шалгалтаар акт, өр төлбөр тавигдах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20.2.6-д “... тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.9 дэх “үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө түрээслүүлэх, бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах” **заалтуудыг зөрчсөн бөгөөд** санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

2022 оны 1 дүгээр улиралд багтаан татварын байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулах, цаашид холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1	“Туулын Хишиг” ОНӨААТҮГ	СЭА-2022/06-НА-СТА-ОНА	Орлогын албан татварын зардлыг тооцоогүй	1	11,819.1	1	11,819.1								-
2			Татвар ногдох зардлыг буруу тооцсон	1	2,543.3	1	2,543.3								-
3			Шууд худалдан авах босго үнээс давсан 63,002.5 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг шууд худалдан авсан.	1	63,002.5					1	63,002.5				
4			Түрээсийн орлогын 20 хувийг Орон нутгийн төсөв төвлөрүүлээгүй	1	28,214.8					1	28,214.8				
5			Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй	1	-					1	-				
6			Түрээсийн орлогыг НӨАТ-ын тайланд дутуу тусгасан	1										1	-

ДҮН				6	105,579.7	2	14,362.4			3	91,217.3			1	-
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
1	“Туулын Хишиг” ОНӨААТҮГ	СЭА- 2022/06- НА-СТА- ОНА	Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд 15 мэдээллийг огт мэдээлээгүй, 46 мэдээллийг хугацаа хоцроосон							1	-	-	-		
	ДҮН			1	-					1	-	-	-		
НИЙТ ДҮН				7	105,579.7	2	14,362.4			4	91,217.3			1	